



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэг 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/103/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Эрдэнэтуяа Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 103

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын үнэлгээний төвийн сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн үнэлгээгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 5,343.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан.

### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 82,113.1 мянган төгрөг, ажил олгогч нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7,930.8 мянган төгрөг, нормативт зардал 6,779.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 385.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 646.9 мянган төгрөгийг хэмнэснээс зарцуулагдаагүй 97,855.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 29-р цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр БСУГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Тайлбар	ӨХМНД	ЭЦӨМНД
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,637,634.37</b>	<b>125,371,560.45</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>19,928,925.34</b>	<b>97,891,648.51</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>	<b>19,928,925.34</b>	<b>97,891,648.51</b>
3121	Төгрөг	19,928,925.34	97,891,648.51
31211	Төрийн сангийн харилцах	19,928,925.34	97,891,648.51
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>22,708,709.03</b>	<b>27,479,911.94</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>285,400.00</b>	<b>160,000.00</b>
35130	Эм боох материал	285,400.00	160,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>22,423,309.03</b>	<b>27,319,911.94</b>
35410	Бичиг хэргийн материал	2,410,000.00	3,237,000.00
35420	Аж ахуйн материал	8,240,470.00	8,813,220.00
35460	Хүнсний материал	4,450,849.03	4,680,281.94
35470	Бусад хангамжийн материал	7,321,990.00	10,589,410.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,450,362,881.91</b>	<b>1,405,245,651.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,450,362,881.91</b>	<b>1,405,245,651.31</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>1,334,174,048.67</b>	<b>1,289,369,318.11</b>
39201	Барилга байгууламж	1,363,999,924.00	1,363,999,924.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(88,982,559.25)	-125,843,329.45
39205	Машин тоног төхөөрөмж	33,399,698.65	35,269,698.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,887,536.52)	(12,194,698.85)
39207	Тавилга, эд хогшил	42,197,936.65	42,517,936.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,884,122.81)	-16,451,031.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,386,390.00	2,386,390.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(324,382.05)	-611,271.09
39217	Ном	268,700.00	295,700.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>116,188,833.24</b>	<b>115,876,333.20</b>
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хасагдуулга	(729,166.76)	(1,041,666.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	115,668,000.00	115,668,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,493,000,516.28</b>	<b>1,530,617,211.76</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>115,668,000.00</b>	<b>257,623,955.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>115,668,000.00</b>	<b>115,668,000.00</b>
51101	Өмч: -төрийн	115,668,000.00	115,668,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,377,332,516.28</b>	<b>1,414,949,211.76</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,392,923,548.01	1,377,332,516.28
51220	Тайлант үеийн үр дүн	(15,591,031.73)	37,616,695.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,493,000,516.28</b>	<b>1,530,617,211.76</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Тайлбар	2017 оны үнэ	2016 оны үнэ
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>442,958,308.33</b>	<b>588,200,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,003,405.00</b>	<b>35,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,003,405.00</b>	<b>35,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,899,905.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	103,500.00	
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>438,954,903.33</b>	<b>588,165,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>393,742,700.00</b>	<b>564,665,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	393,742,700.00	564,665,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,212,203.33</b>	<b>23,500,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,212,203.33	23,500,000.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>458,549,340.06</b>	<b>550,583,304.52</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>458,549,340.06</b>	<b>550,583,304.52</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>448,543,641.39</b>	<b>546,774,035.56</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>286,798,434.01</b>	<b>358,414,026.97</b>
210101	Үндсэн цалин	214,345,003.77	264,867,468.86
210102	Нэмэгдэл цалин	43,628,539.24	81,829,388.81
210104	Урамшуулал	15,284,991.00	11,717,169.30
210106	Гэрээт ажлын хөлс	13,539,900.00	
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>36,616,327.48</b>	<b>45,871,202.74</b>
210201	Тэтгэврийн даатгалын	25,111,356.70	31,810,580.86
210202	тэтгэмжийн даатгалын	2,942,944.33	3,722,457.44
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,307,294.96	2,887,566.02
210204	Ажилгүйдлийн даатгалын	571,676.45	674,054.32
210205	ЭМ-ийн даатгалын	5,683,055.04	6,776,544.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,178,461.33</b>	<b>21,864,431.04</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	3,695,957.39	5,997,302.26
210302	Түлш, халаалтын зардал	4,906,008.78	6,281,254.94
210303	Цэвэр бохир усны зардал	6,576,495.16	9,585,873.84
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,192,090.00</b>	<b>4,157,460.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	4,068,210.00	2,870,940.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	47,610.00	1,286,520.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,076,270.00	-
2105	<b>Нормативт зардал</b>	<b>47,654,522.27</b>	<b>60,785,944.09</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	625,460.00	125,400.00
210502	Хоол, хүнс	47,029,062.27	60,660,544.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,723,050.00</b>	<b>1,300,000.00</b>
210604	Урсгал засварын зардал	1,723,050.00	1,300,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>491,599.98</b>	<b>640,400.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	491,599.98	640,400.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,889,156.32</b>	<b>53,740,570.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,307,500.02	6,406,340.12
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	257,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,324,656.30	47,334,230.60
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>10,005,698.67</b>	<b>3,809,268.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,429,100.00</b>	<b>3,473,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,429,100.00	3,473,700.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,576,598.67</b>	<b>335,568.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,576,598.67	335,568.96
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(15,591,031.73)</b>	<b>37,616,695.48</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	-	-
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(15,591,031.73)</b>	<b>37,616,695.48</b>

/төгрөгөөр/

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Тайлбар	Эхний үеийн үнэ	Эцсийн үеийн үнэ
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>438,954,903.33</b>	<b>588,200,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>35,000.00</b>
120002	Хүүгийн орлого		
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>35,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>438,954,903.33</b>	<b>588,165,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>393,742,700.00</b>	<b>564,665,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	393,742,700.00	564,665,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,212,203.33</b>	<b>23,500,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,212,203.33	23,500,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>414,456,287.99</b>	<b>508,020,276.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>414,456,287.99</b>	<b>508,020,276.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>404,450,589.32</b>	<b>504,211,007.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>286,798,434.01</b>	<b>358,414,026.97</b>
210101	Үндсэн цалин	214,345,003.77	264,867,468.86
210102	Нэмэгдэл	43,628,539.24	81,829,388.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	
210104	Урамшуулал	15,284,991.00	11,717,169.30
210105	Гэрээт ажлын хөлс	13,539,900.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,616,327.48</b>	<b>45,871,202.74</b>
210201	Тэтгэврийн даатгалын	25,111,356.70	31,810,580.86
210202	Тэтгэмжийн даатгалын	2,942,944.33	3,722,457.44
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,307,294.96	2,887,566.02
210204	Ажилгүйдлийн даатгалын	571,676.45	674,054.32
210205	Эрүүл мэндийн даатгалын	5,683,055.04	6,776,544.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,178,461.33</b>	<b>21,864,431.04</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	3,695,957.39	5,997,302.26
210302	Түлш, халаалтын зардал	4,906,008.78	6,281,254.94
210303	Цэвэр бохир усны зардал	6,576,495.16	9,585,873.84
210304	Байрны түрээс		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,787,856.50</b>	<b>60,889,977.00</b>
210501	Эм	-	
210502	Хоол, хүнс	49,787,856.50	60,889,977.00
210503	Нормын хувцас		
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>1,843,550.00</b>	<b>1,300,000.00</b>
210604	Урсгал засвар	1,843,550.00	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	-	
210702	Дотоодын томиллолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>956,599.98</b>	<b>683,300.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	956,599.98	683,300.00
210807	Газрын төлбөр		

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,269,360.02</b>	<b>15,188,070.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,775,650.02	12,419,280.12
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,493,710.00	2,768,790.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,005,698.67</b>	<b>3,809,268.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,429,100.00</b>	<b>3,473,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,429,100.00	3,473,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,576,598.67</b>	<b>335,568.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,576,598.67	335,568.96
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	<b>-</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>24,498,615.34</b>	<b>80,179,723.17</b>
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>4,569,690.00</b>	<b>2,217,000.00</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>4,569,690.00</b>	<b>2,217,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,569,690.00</b>	<b>2,217,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	4,569,690.00	2,217,000.00
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,569,690.00)</b>	<b>(2,217,000.00)</b>
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>19,928,925.34</b>	<b>77,962,723.17</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>19,928,925.34</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19,928,925.34</b>	<b>97,891,648.51</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үйлдэл	2021 оны 12 дугаар сарын 31-нээрсний үлдэгдэл	Дахин үнэлгээний өөрчлөлт	Хөрөнгө/өмчийн өөрчлөлт	2022 оны 12 дугаар сарын 31-нээрсний үлдэгдэл
A	1	2	3	4
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрс үлдэгдэл</b>	<b>115,668,000.00</b>	-	<b>1,392,923,548.01</b>	<b>1,508,591,548.01</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-		-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(15,591,031.73)	<b>(15,591,031.73)</b>
<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрс үлдэгдэл</b>	<b>115,668,000.00</b>	-	<b>1,377,332,516.28</b>	<b>1,493,000,516.28</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			37,616,695.48	<b>37,616,695.48</b>
<b>2023 оны 12 дугаар сарын 31-нээрс үлдэгдэл</b>	<b>115,668,000.00</b>	-	<b>1,414,949,211.76</b>	<b>1,530,617,211.76</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэсэн	Зөрөл	Хүрээ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,928,925.34		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	620,977,000.00	509,901,707.87	(111,075,292.13)	82.1
21	Урсгал зардлын дүн	620,977,000.00	509,901,707.87	(111,075,292.13)	82.1
210	Бараа үйлчилгээний зардал	617,503,300.00	506,428,007.87	(111,075,292.13)	82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,527,100.00	358,414,026.97	(82,113,073.03)	81.4
210101	Үндсэн цалин	289,014,000.00	264,867,468.86	(24,146,531.14)	91.6
210102	Нэмэгдэл	138,688,100.00	81,829,388.81	(56,858,711.19)	59
210104	Урамшуулал	12,825,000.00	11,717,169.30	(1,107,830.70)	91.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,802,000.00	45,871,202.74	(7,930,797.26)	85.3
210201	Тэтгэврийн даатгал	36,585,100.00	31,810,580.86	(4,774,519.14)	86.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,304,300.00	3,722,457.44	(581,842.56)	86.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,443,200.00	2,887,566.02	(555,633.98)	83.9
210204	Ажилгүйдлийн даатгал	861,200.00	674,054.32	(187,145.68)	78.3
210205	ЭМД-ын хураамж	8,608,200.00	6,776,544.10	(1,831,655.90)	78.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,084,000.00	21,864,431.04	(13,219,568.96)	62.3
210301	Гэрэл цахилгааны зардал	13,528,100.00	5,997,302.26	(7,530,797.74)	44.3
210302	Түлш, халаалтын зардал	11,443,900.00	6,281,254.94	(5,162,645.06)	54.9
210304	Цэвэр бохир усны зардал	10,112,000.00	9,585,873.84	(526,126.16)	94.8
2105	Нормативт зардал	67,669,400.00	60,889,977.00	(6,779,423.00)	90
210502	Хоол хүнс	67,669,400.00	60,889,977.00	(6,779,423.00)	90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,300,000.00	-	100
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,068,800.00	683,300.00	(385,500.00)	63.9
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,068,800.00	683,300.00	(385,500.00)	63.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,052,000.00	17,405,070.12	(646,929.88)	96.4

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,845,600.00	14,636,280.12	(209,319.88)	98.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,206,400.00	2,768,790.00	(437,610.00)	86.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,473,700.00	3,473,700.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,473,700.00	3,473,700.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,473,700.00	3,473,700.00	-	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	620,977,000.00	587,864,431.04	(33,112,568.96)	91.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,593,000.00	564,665,000.00	(19,928,000.00)	96.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	584,593,000.00	564,665,000.00	(19,928,000.00)	96.6
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,384,000.00	23,164,431.04	(13,219,568.96)	63.7
132001	Орон нутгийн төсвөөс	36,384,000.00	23,164,431.04	(13,219,568.96)	63.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	35,000.00	0.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	35,000.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		97,891,648.51	97,891,648.51	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
3	Төсвийн байгууллага	1	1	-	100
	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	100
	Удирдах ажилтан	1	1	-	100
	Гүйцэтгэх ажилтан	17	17	-	100
	Үйлчлэх ажилтан	7	7	-	100

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн 29 дүгээр цэцэрлэг нь "Зөв харилцаа хандлагатай, тэгш эрхтэй хамт олонг бүрдүүлж хүүхдийн эрхийг дээдлэн хүндэтгэж, эрүүл аюулгүй орчинд хүүхдийн сурах үйлийг эрхэмлэж, хөгжил хамгааллын цогц үйлчилгээг хамтын ажиллагаанд суурилан хүргэнэ" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

## **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,097.6 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,928.9	97,891.6	77,962.7
Авлага	-	-	-
Бараа материал	22,708.7	27,479.9	4,771.2
Үндсэн хөрөнгө	1,450,362.8	1,405,245.6	(45,117.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,493,000.5</b>	<b>1,530,617.2</b>	<b>(37,616.7)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,493,000.5	1,530,617.2	37,616.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,493,000.5</b>	<b>1,530,617.2</b>	<b>37,616.7</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 97,891.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27,479.9 мянган төгрөг болж 4,771.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 71,014.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 66,243.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,405,245.6 мянган төгрөг болж 45,117.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,870.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 27.0 мянган төгрөгийн ном худалдаж аван тайлант онд 47,334.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,530,617.2 мянган төгрөг болж 37,616.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт** Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 580,085.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,460.5 мянган төгрөг нийт зарлагыг 610,546.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд нийт төсвийг 471,686.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 оны 6 сард хүүхдэд ээлтэй сургалтын орчинд 3,297.2 мянган төгрөгийн төсөв, Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор 9 сард цалинд 113,289.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 12,897.2 мянган төгрөг, 10 сард гүйцэтгэлийн үнэлгээгээр 4-р түвшинд үнэлэгдсэн тул 5,344.1 мянган төгрөг мөн цалинд 1,337.2 мянган төгрөг нийгмийн даатгалын шимтгэлд

167.2 мянган төгрөг, 11 сард нэмэлтээр хоолны зардалд 6,500 мянган төгрөг БҮБЗардалд 700.0 мянган төгрөг, 12 сард нэмэлтээр үндсэн цалинд 6,855.5 мянган төгрөг НДШ-д 856.9 мянган төгрөг, хоолны зардал 1,976.5 мянган төгрөгийн төсвөөр тус тус 5 удаа өөрчлөлт орж нийт улсын төсөв 584,593.0 мянган төгрөг болж нэмэгдсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 584,593.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,384.0 мянган төгрөг нийт 620,977.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 23,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 23,164.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 335.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 564,665.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 486,702.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 97,891.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 665,585.6 мянган төгрөг буюу 84.3 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 123,269.6 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө,*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-СӨБ	620,977.00	509,901.7	(111,075.3)	82.1
1.1	80111- Тогтмол зардал	23,535.0	23,199.4	(335.60)	98.6
1.2	81605- Эрүүл мэндийг	1,603.2	1,557.6	(45.60)	97.2
1.3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	65,450.8	60,889.9	(4,560.90)	93.0
1.4	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,297.2	3,297.2	-	100.0
1.5	81823- Боловсролын багшийн сургалт	1,603.2	1,601.0	(2.20)	99.9
1.6	81834- Боловсролын стандарт сургалт	408,647.1	315,458.0	(93,189.10)	77.2
1.7	81835- Сургалтын хэвийн үйл	116,840.5	103,898.6	(12,941.90)	88.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага

нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

#### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Э.Эрдэнэбат, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 270,778.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,707.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2023 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалингийн зардлыг 82,113.1 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 7,930.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13,219.6 мянга, хоол хүнсний зардал 6,779.4 мянгаар нэмэгдэж, бараа үйлчилгээний бусад зардлыг 646.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 719.8 мянган төгрөгийн 3 зөрчлийн биелэлтийг шалгахад зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	719.8	1	719.8	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>719.8</b>	<b>1</b>	<b>719.8</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар засгийн газрын санг 115,668.0 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасныг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 1,263.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 төлбөрийн акт тогтоолоо.

## 5.1 Төлбөрийн акт

5.1.1 **Илрүүлэлт:** Тус цэцэрлэг нягтлан бодогч Ц.Лэгжмаагийн ээлжийн амралтын дундаж цалин хөлсийг буруу тооцоолон 86.3 мянган төгрөг илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *"Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"*-ын 3.4-т *"Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно"* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.1.2 **Илрүүлэлт:** Тус цэцэрлэг багш, туслах багшийн ажлын цагийн фондоос илүү цагийг тооцохдоо 276.2 мянган төгрөг илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан *Цэцэрлэгт ээлжийн багш туршилтаар ажиллуулахад мөрдөх түр журам*—ын 6.2 дахь заалтад *"..ээлжийн багш ажиллаагүй өдрөөр бүлгийн багшид цагийн бүртгэлийг үндэслэн өдөрт илүү 2 цагийн хөлс тооцож олгоно"*, 6.5 дахь заалтад *"ээлжийн багшид багшид дэмжлэг үзүүлэн ажилласан бүлгийн багшид өдөрт илүү 1 цагийн хөлс тооцон олгоно"* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов

5.1.3 **Илрүүлэлт:** Тус цэцэрлэг тогооч, үйлчлэгч, нярав, нягтлан бодогч зэрэг 7 ажилтанд тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй байж ур чадварын нэмэгдэл 900,9 мянган төгрөг олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан *"Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"*-ын 5 дахь заалтад *"ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул акт тогтоов.*

## 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

### **5.3 Зөвлөмж**

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аудитаар засгийн газрын санг 115,668.0 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан	1	115,668.0	-	-	-	-	1	115,668.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>115,668.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>115,668.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Тус цэцэрлэг нягтлан бодогч Ц.Лэгжмаагийн ээлжийн амралтын дундаж цалин хөлсийг буруу тооцоолон 86.3 мянган төгрөг илүү олгосон.	1	86.2	1	86.	-	-	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэг багш, туслах багшийн ажлын цагийн фондоос илүү цагийг тооцохдоо 276.2 мянган төгрөг илүү олгосон.	1	276.2	1	276.2									
Тус цэцэрлэг тогооч, үйлчлэгч, нярав, нягтлан бодогч зэрэг 7 ажилтанд тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтээр	1	900.9	1	900.9									

дүгнээгүй байж ур чадварын нэмэгдэл 900,9 төгрөг олгосон												
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,263,3</b>	<b>1</b>	<b>1,263.3</b>	<b>-</b>							